

**ЖАРГАЛТХААН СУМЫН МАН-ЫН ХОРООНЫ 2020 ОНЫ  
ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сумынхаа хөгжлийн  
төлөө хүчээ нэгтгэе.

**Өмнөтгөл**


Хийж хэрэгжүүлэх ажлуудыг нэгтгэж дүгнэвэл ирэх дөрвөн жилд шударга ёсны хувьсгал өргөжиж, хүний хөгжлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийн үр шимийгиргэн бүрд бодитой хүргэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

**Нэг. Нийгмийн бодлогын хүрээнд:**

- 1.1 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3 Хавдрын эсрэг хамтдаа “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4 Сумын эмнэлгийг халуун, хүйтэн, ус ариун цэврийн байгууламжтай болгоно.
- 1.5 ЕБС, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмж, урамшууллыг инфляцын түвшинтэй уялдуулж, үе шаттай нэмэгдүүлнэ.
- 1.6 Нүхэн жорлонтой сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгоно.
- 1.7 Ахмадуудад суурь тэтгэвэр олгож, тэтгэврийндоод хэмжээг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлнэ.
- 1.8 12 жилийн сургалттай 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.
- 1.9 Өрх толгойлсон цалингүй, тэтгэвэргүй, улсаас ямар нэгэн халамж авдаггүй өөрийн зүтгэлээрээ бизнес эрхэлж өрх гэрээ авч яваа хүмүүст бодитой дэмжлэг үзүүлнэ.
- 1.10 Сумын төвийн халуун усны үйлчилгээг өргөтгөн саунтай болгож сайжруулна.

**Хоёр. Хөдөө аж ахуйн салбарт:**

- 2.1 Малчин, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.2 Илгээлтийн эзэн-III аяныг хэрэгжүүлж малчдын залгамж халаад дэмжлэг үзүүлнэ.
- 2.3 “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлнэ.
- 2.4 Малыг бүртгэлжүүлэх ажлыг боловсронгуй болгож, бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай болж, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог сайжруулж малын хулгайг бууруулахад ахиц гаргана.
- 2.5 Малын эм, тарилга, вакциныг дотооддоо бүрэн хангаж баталгаагүй, зааварчлагагүй эм, тарилгаас татгалзана.
- 2.6 Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир, ноос, ноолуур, түүхий эд бэлтгэн тушаасан малчинд мөнгөн урамшуулал олгох тогтолцоог улам сайжруулна.
- 2.7 Талхлагдсан бэлчээрийг сэргээх, хортон, шавьжтай тэмцэх ажлыг нутгийн иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 2.8 Ашиглагдах боломжтой бэлчээрийг усжуулах ажлыг хэрэгжүүлнэ.





2.9 Орон нутгийг хүнсний эко бүтээгдэхүүнээр хангахын тулд 1 га хүртлэх атаржсан талбайг услалтын системтэй болгож иргэдийг хүнсний ногоо тарих боломжийг бүрдүүлнэ.

### Гурав. Бусад асуудлын хүрээнд:

3.1 Аялал жуулчлалын маршрутын гол зангилаанд багтаж буйн хувьд дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

- Аялагчдын түр буудаллах боловсон ОО, кофе шоп, бэлэг дурсгалын дэлгүүр бүхий үйлчилгээний цогцолборыг хувийн хэвшлийноролцоотойгоор байгуулна.
- Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,Чингисхаан одонт Урлагийн гавъяат зүтгэлтэн, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Б.Шаравын урланг өргөтгөн музей, урлан болгохын зэрэгцээ орчныг тохижуулж гэр камп,кофе шоп,бакеи байгуулах.
- Үзүүр толгой, гандан хийд, суварга, Б.Шаравын урлан музейг холбосон явган хүний зам, ногоон байгууламж, гэрэлтүүлэг бий болгож, үзүүр толгойн орой дээр сумын онцлогийг харуулсан өндөрлөг босгож, иргэдийн амарч тухлах нөхцлийг бүрдүүлнэ.
- Сумаар дайран өнгөрч буй төв зам, сумаас Өмнөдэлгэр чиглэлд тавих засмал замын дагуу ногоон байгууламж бий болгоно.
- Үйлчилгээний цогцолборын орчинд морь,тэмээ, сарлаг унуулах, зураг авч угаах, сумын иргэдийн бренд бүтээгдэхүүн борлуулах үйлчилгээ бий болгоно.
- Барууны арын гэлэн хөшөө, Дуулгын булш зэрэг түүх дурсгалын бүтээлийг хашаажуулж түүхийг нь бичиж байршуулна.
- Өндөр хурдны интернет бүхий шилэн кабелийг гол гол газруудад татна.

3.2 Модон жорлонгоос салж эко ОО-той болгох ажлыг туршилтын журмаар зарим үйлчилгээний төв, гэр хорооллын зарим эгнээнд хэрэгжүүлнэ.

3.3 Жаргалтхаанаас Өмнөдэлгэр, Биндэр сумыг холбосон хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ.

3.4 Нутгийн бренд бүтээгдэхүүн бий болгох замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх болон борлуулалтын сүлжээнд нь бодит дэмжлэг үзүүлнэ.

3.5 Төрийн ажлын хүнд суртал, намчирхалыг бүрэн арилгаж, төрөөс үзүүлдэг дэмжлэг, хөнгөлөлтийг эзнээ олсон эсэхэд олон түмний оролцоо, хяналтыг сайжруулна.

3.6 Гамшгаас хамгаалах бүлгийн ажлыг эко орчин бүрдүүлэх, гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, энэ талаар хийх сургалт сурталчилгааг шинэ шатанд гаргахад бүрэн чиглүүлнэ.

3.7 ГХБүлгийн шинэ байрны асуудлыг шийдвэрлүүлнэ.

3.8 Суманд ажлын байр бий болгох, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд сүүний үйлдвэр, нарийн боовны цех, гутлын болон түүхий эд боловсруулах цехүүдийг байгуулах замаар гүүний саам хатаах, ээдэмцэр, зайрмаг, нарийн боов,талх үйлдвэрлэх, тараг, цөцгий савлах, бэлэг дурсгалын жижиг зүйлс хийх үйл ажиллагааг эхлүүлнэ.

3.9 Эх орноо хөгжүүлэхийн төлөө зүтгэж ирсэн намын гишүүнчлэлийн улмаас хөдөлмөрөө үнэлүүлж чадаагүй ахмадуудын шагналын асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

3.10 Сумын нутаг дэвсгэрт үүл уурхайн лиценз шинээр олгохгүй бөгөөд хуучин хайгуул, ашиглалт хийсэн талбайнуудыг нөхөн сэргээлгэх асуудлыг шийднэ.

3.11 Сумын төвийн гэрэлтүүлэггүй гудамжуудыг гэрэлтүүлэгтэй болгоно.



144297  
40 90740